



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 1/112

Хэрлэн сум

Орон тооны бус салбар зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйл, Засгийн газрын 2016 оны 233 дугаар тогтоол, Шадар сайдын 2017 оны 43 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр", Монгол Улсын Шадар сайдын 2017 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 43 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор Аймгийн Засаг даргын дэргэд төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Салбар зөвлөлийн дарга:

-Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:

-Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд

-Статистикийн хэлтсийн дарга

-Онцгой байдлын газрын дарга

-Мэргэжлийн хяналтын газрын дарга

-Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга

-Аймгийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл

-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн худалдаа үйлчилгээ, хүнс хөдөө аж ахуй үйлдвэрлэлийн бодлого хариуцсан мэргэжилтэн

-Худалдаа аж үйлдвэрийн танхимын Хэнтий аймаг дахь салбарын тэргүүн

2. "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр", Шадар сайдын 2017 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 43 дугаар тушаалыг орон нутагт хэрэгжүүлэх орон тооны бус салбар зөвлөлийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг орон тооны бус салбар зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

